

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-108-ЫН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Агаарын тээвэрлэгчийн <u>аюулгүйн хамгаалалтын</u> хөтөлбөр (Шинэчлэгдэж байгаа) /12 хуудас/2015 оны NZ amend. 11</p>	<p>Агаарын тээвэрлэгчийн <u>аюулгүй байдлын</u> хөтөлбөр (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /7 хуудас (үндсэн дүрэм- 19 хуудастай байсан)/1997 оны NZ original</p>	<p>Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ / GENERAL</p>	
<p>108.1. Хамрах хүрээ Энэ Дүрэм нь ИНД-119 болон ИНД-129-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>108.1 Зорилго Энэ дүрмээр ИНД-119, ИНД-129-ийн дагуу гэрчилгээжижээр өргөдөл гаргаж буй агаарын тээвэрлэгчийн Аюулгүй байдлын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтооно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>108.3. Нэр томъёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>	<p>108.3 Тодорхойлолт</p>	<p>Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>В Бүлэг - Агаарын тээвэрлэгчийн <u>аюулгүйн хамгаалалтын</u> хөтөлбөрийн шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН <u>АЮУЛГҮЙ БАЙДЛЫН</u> ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД</p>	
<p>108.51. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь дараах мэдээллийг багтаана:</p> <p>(1) агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн хэрэгжүүлэлттэй холбоотой ажлыг бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхийг төлөвлөж байгаа бол тухайн гэрээт, эсхүл бусад байгууллага нь уг агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж байгааг бататгах гэрээний нөхцөлийг;</p> <p>(2) 108.59-д шаардсан журмын дагуу, ажилтнуудын сургалт хариуцсан этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг;</p> <p>(3) дараах журмаар шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг:</p> <p>(i) 108.53 - орон нутгийн аюулгүйн хамгаалалтын шаардлагын талаар;</p> <p>(ii) 108.55 - олон улсын аюулгүйн хамгаалалтын шаардлагын талаар;</p> <p>(iii) 108.57 - <u>агаарын хөлгийн нислэгт олгох зөвшөөрлийн талаар</u>;</p> <p>(iv) 108.59 - ажилтнуудын сургалтын талаар;</p> <p>(v) 108.61 - зөрчлийг мэдээлэх болон тайлан гаргах талаар.</p>	<p>108.5. Агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр</p> <p>(а) Монгол Улсын аль ч аэродромоос зорчигч тээврийн нислэг үйлдэх Агаарын тээвэрлэгч (цаашид Тээвэрлэгч гэх) нь Аюулгүй байдлын хөтөлбөртэй байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д заасан Аюулгүй байдлын хөтөлбөрт дор дурьдсан зүйлийг тусгасан байна. Үүнд:</p> <p>1/ Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ (АТГ) авахаар өргөдөл гаргагч энэ дүрэмд заасан үйл ажиллагааг бусад байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан тохиолдолд гэрээт байгууллага нь өргөдөл гаргагчийн Аюулгүй байдлын хөтөлбөрийг мөрдөж ажиллах тухай гэрээний нөхцлүүд;</p> <p>2/ энэ дүрмийн 108.13-т заасны дагуу сургалт хариуцсан ажилтанд тавигдах шаардлага, ажлын байрны тодорхойлолт;</p> <p>3/ дараах зүйлүүд:</p> <p>(i) энэ дүрмийн 108.7-д заасан орон нутгийн нислэгт тавигдах аюулгүй байдлын шаардлага;</p> <p>(ii) энэ дүрмийн 108.9-д заасан олон улсын нислэгт тавигдах аюулгүй байдлын шаардлага;</p> <p>(iii) энэ дүрмийн 108.11-д заасан баталгаа;</p> <p>(iv) энэ дүрмийн 108.13-т заасан ажиллагсдын сургалт;</p> <p>(vi) энэ дүрмийн 108.15-д заасан зөрчлийн мэдээ, тайлан.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>108.53. Аюулгүйн хамгаалалтын шаардлага - Орон нутаг</p>	<p>108.7. Аюулгүй байдлын шаардлага- орон нутгийн нислэгт</p>	

<p>(a) Орон нутгийн <u>ТОГТМОЛ</u> агаарын тээврийн зорчигч үйлчилгээний агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь Монгол Улс дотор гүйцэтгэж байгаа нислэгийн зорчигч, багийн гишүүд, газрын ажилтан, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын журамтай байх ёстой.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын журам нь дараах арга хэлбэрийг тогтоох ёстой:</p> <p>(1) агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх ИНД-91.9-ийн шаардлагыг хангах;</p> <p>(2) агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл бусад хууль бус үйлдлийн заналхийлэл бий болсон үед агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын ажилтанд учрах аюулыг багасгах;</p> <p>(3) тухайн агаарын хөлгийг хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор агаарын тээвэрлэгчийн хяналтгүй орхисон агаарын хөлөгт нэвтрэх үйлдэлд байнга хяналт тавих;</p> <p>(4) Монгол Улсын доторх аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүс болон бусад аэродромын үйл ажиллагааны бүсэд агаарын тээвэрлэгчийн байгууламжаар дамжин нэвтрэх, эсхүл агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтан, тээш, ачаа, багц ачаа, эсхүл агаарын хөлгийн хангалтад ашигладаг бусад хаалгаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>(5) тухайн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгаа тээш, ачаа, илгээмж шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангалтад зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;</p> <p>(6) хэрэв тухайн агаарын хөлгийн бүхээгт хуулийн дагуу саатуулагдсан, эсхүл хууль хяналтын байгууллагын хяналтад аялах шаардлагатай 1, эсхүл хэд хэдэн этгээдийг тээвэрлэх бол, <u>тэднийг харгалзагчтай байхыг шаардсан эсэхээс үл хамааран, нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангаж, хөлгийн даргад мэдэгдэх;</u></p> <p>(7) <u>хэрэв зорчигч тухайн агаарын хөлөгт сүүгаагүй бол, агаарын тээвэрлэгч болон хөлгийн дарга эрсдэлийг үнэлж, агаарын хөлөгт байгаа зорчигчийн тээшийг тээвэрлэх эсэхийг шийдэх;</u></p> <p>(8) <u>хэрэв Сайд, эсхүл Дарга</u> хууль бус үйлдэл хийхэд</p>	<p>(a) Монгол Улсын нутаг дэвсгэрт орон нутгийн зорчигч тээврийн нислэг үйлдэх Тээвэрлэгчийн Аюулгүй байдлын хөтөлбөрт зорчигч, агаарын хөлгийн нисэх баг болон багийн бусад гишүүд, газрын үйлчилгээний ажилтан, агаарын хөлөг, тоног төхөөрөмжийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах журмыг тусгасан байна.</p> <p>(б) Энэхүү зүйлийн (a)-д заасан журамд дараахь шаардлагыг тусгасан байна:</p> <p>1/ ИНД-91.9-д заасан, агаарын хөлгийн бүхээгт зэвсэг тээвэрлэхэд тавигдах шаардлагыг мөрдөх;</p> <p>2/ агаарын хөлгийг булаан эзлэх, тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбоотой бусад заналхийлэл бий болсон тохиолдолд агаарын тээвэрлэгчийн зорчигч, нисэх баг болон багийн бусад гишүүд, газрын үйлчилгээний ажилтанд учрах аюулыг багасгахад чиглэсэн арга хэмжээ авах;</p> <p>3/ үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор аюулгүй байдлын хяналт тавих;</p> <p>4/ нисэх буудлын хамгаалагдсан болон хориотой бүс, тухайн бүсүүд дэх агаарын тээвэрлэгчийн барилга байгууламжид нэвтрэхэд тээш, ачаа, шуудангийн илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан ба эд зүйлст аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;</p> <p>5/ агаарын хөлгөөр тээвэрлэх тээш, ачаа, шуудангийн илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан ба эд зүйлст аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;</p> <p>6/ хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг ба түүнээс дээш этгээдийг тээвэрлэх тохиолдолд агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байх;</p> <p>7/ нислэгээс хоцорсон зорчигчийн тээшийг тээвэрлэхийг хориглох;</p> <p>8/ агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж</p>	<p>-“Зорчигч тээврийн тогтмол нислэг” гэсэн шаардлагыг тодруулсан</p> <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Халдлага зөвхөн хөндлөнгөөс байдаггүй, дотроосоо ч байж болдог тул “хөндлөнгийн” гэснийг хассан</p> <p>-Amend.10-аар өөрчлөгдсөн</p>
---	---	---

ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт авч орохоос сэргийлэх зорилгоор бүх зорчигч, багийн гишүүд болон тэдгээрийн гар тээшинд аюулгүйн үзлэг хийхийг шаарддаг бол, тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт орохын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;

(9) хэрэв Сайд, эсхүл Дарга хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйл, эсхүл бодис агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачигдахаас сэргийлэх зорилгоор, гар тээшнээс бусад бүх тээшинд аюулгүйн үзлэг хийхийг шаарддаг бол, тэдгээрийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;

(10) хэрэв Дарга, агаарын хөлөгт байгаа этгээд, эсхүл агаарын хөлөг, эсхүл аэродромд учрах аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илрүүлсэн, эсхүл сэжиглэж байгаа бөгөөд энэ нь орон нутгийн нислэгийн үйл ажиллагаанд хамгаалалтын нэмэлт арга хэмжээг шаардаж байгаа бол тухайн агаарын тээвэрлэгчийн үйлчилгээний аюулгүйн хамгаалалтыг сайжруулах хамгаалалтын түр арга хэмжээг авах;

(11) нислэгийн үед агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлэх.

(с) Энэ зүйлийн (b)(6)-д шаардсан журам нь, тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний нислэгээр хуулийн дагуу саатуулагдсан этгээдийг тээвэрлэхтэй холбоотой дараах арга хэмжээг бататгах журмыг багтаасан байх ёстой:

болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлс нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зорчигч, нисэх баг болон багийн бусад гишүүд, тэдгээрийн авч яваа гар тээшид аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;

9/ агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон аюултай зүйлс нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гар тээшнээс бусад бүх тээшинд агаарын хөлөгт ачихын өмнө аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;

10/ агаарын хөлөг дэх хүмүүс, агаарын хөлөг болон нисэх буудлын эсрэг заналхийллийн түвшин нэмэгдсэн үед Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тогтоох нисэх буудал, агаарын тээвэрлэгчийн хэрэгжүүлэх аюулгүй байдлын түр зуурын нэмэлт арга хэмжээний талаар;

11/ агаарын хөлөгт нислэгийн өмнө зэвсэг, аюултай бодис болон эд зүйлсийг илрүүлэх зорилгоор үзлэг, шалгалт хийх;

12/ агаарын хөлөгт сэжигтэй зүйл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлс, нуусан зэвсэг хайх үед ашиглах шалгах хуудсыг агаарын хөлгийн бүхээгт байрлуулна. (Жич: Сэжигтэй зүйл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлс, нуусан зэвсэг хайх, илэрсэн тохиолдолд түүнийг байрлуулах агаарын хөлгийн хамгийн бага эрсдэлтэй байрлалыг шалгах хуудсанд заасан байх шаардлагатай.)

13/ нислэгийн үед агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

(в) Зорчигч тээврийн хуваарьт нислэгээр энэ зүйлийн (б)-гийн 6/-д заасан этгээдийг тээвэрлэх тохиолдолд дараахь шаардлагыг хангасан байна:

-Тухайн нислэгээс хоцорсон зорчигчийн тээшийг тээвэрлэхийг хориглодог байсныг өөрчилж, эрсдлийг үнэлсний үндсэн дээр тээвэрлэх эсэхийг шийдэх эрхийг Агаарын тээвэрлэгч болон хөлгийн даргад олгосон

-“Сайдын, эсхүл Даргын шаардсан тохиолдолд үзлэг хийх” гэсэн шаардлага нэмэгдсэн

- (1) тухайн этгээд нь харгалзагчтай байх;
- (2) харгалзагч нь тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болох эд зүйл авч яваагүй болохыг бататгах;
- (3) харгалзагч нь тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлахад тохирох хэрэгслээр тоноглогдсон байх;
- (4) тухайн этгээдийн суудлын байрлал болон аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар хөлгийн дарга болон бүхээгийн ахлах ажилтанд мэдэгдэх;
- (5) тухайн этгээд, түүний харгалзагчид согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх;
- (6) тухайн этгээдийн хэрэглээнд металл хэрэгсэл ашиглахгүй байх;
- (7) тухайн этгээдийг ослын гарцын зэргэлдээх суудалд, эсхүл эгнээнд суулгахгүй байх;
- (8) тухайн этгээдийг нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн суудалд суулгах;
- (9) 29, эсхүл түүнээс цөөн гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай агаарын хөлөгт 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг тээвэрлэх ба гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжийн нэмэлт 25 суудал бүрд 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг нэмж тээвэрлэх.

- 1/ тухайн этгээдийг харгалзагч дагалдсан байх;
- 2/ тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болохуйц ямар нэг эд зүйл авч яваагүй гэдгийг түүнийг харгалзагч батламжлах;
- 3/ тухайн этгээдийн харгалзагч нь хамгаалах хэрэгсэлтэй байх;
- 4/ агаарын хөлгийн дарга болон ахлах үйлчлэгчид тухайн этгээдийн суудлын дугаар болон аюулгүй байдлын арга хэмжээний талаар мэдэгдсэн байх;
- 5/ тухайн этгээд, түүнийг харгалзагч нарт спиртийн төрлийн ундаа, хоолны төмөр хэрэгслээр үйлчлэхгүй байх;
- 6/ тухайн этгээдийг агаарын хөлгийн аваарын хаалганы хажууд буюу аваарын хаалганы суудалтай эгнээнд суулгахгүй байх;
- 7/ тухайн агаарын хөлгийн зорчигчийн суудал 29 хүртэл бол харгалзагчтай тээвэрлэх этгээдийн тоо нэгээс дээшгүй, 29-өөс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлөгт 25 суудал тутамд нэг байна.

-Орчуулга, найруулга зассан

108.55. Аюулгүйн хамгаалалтын шаардлага - Олон улс

- (a) Олон улсын ТОГТМОЛ агаарын тээврийн зорчигч үйлчилгээний агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь Монгол Улс дотор, эсхүл Монгол Улсаас гүйцэтгэж байгаа нислэгийн зорчигч, багийн гишүүд, газрын ажилтан, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын журамтай байх ёстой.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын журам нь дараах арга хэлбэрийг тогтоох ёстой:
- (1) агаарын хөлгийн бүхээгт галт зэвсэг тээвэрлэх ИНД-91.9-ийн шаардлагыг хангах;
 - (2) агаарын хөлгийг булаах, тэсрэх бөмбөгийн заналхийлэл, эсхүл хууль бус үйлдлийн бусад заналхийлэл бий болсон үед агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүд болон газрын ажилтанд учрах аюулыг багасгах;
 - (3) агаарын тээвэрлэгчийн хяналтгүй орхисон агаарын хөлгийг хууль бус үйлдлээс сэргийлэх зорилгоор тухайн

108.79. Аюулгүй шаардлага - олон улсын нислэгт

- (a) Монгол Улсаас зорчигч тээврийн олон улсын нислэг үйлдэх Тээвэрлэгч нь Аюулгүй байдлын хөтөлбөртэй байх ба энэ хөтөлбөрт зорчигч, нисэх баг, газрын ажилтан, агаарын хөлөг, тоног төхөөрөмжийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүй байдлын журмыг тусгасан байна.
- (б) Энэхүү зүйлийн (a)-д заасан журамд дараахь шаардлагыг тусгасан байна:
- 1/ ИНД-91.9-д заасан, агаарын хөлгийн бүхээгт зэвсэг тээвэрлэхэд тавигдах шаардлагыг мөрдөх;
 - 2/ агаарын хөлгийг булаан эзлэх, тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбоотой бусад заналхийлэл бий болсон тохиолдолд агаарын тээвэрлэгчийн зорчигч, нисэх баг болон багийн бусад гишүүд, газрын үйлчилгээний ажилтанд учрах аюулыг багасгахад чиглэсэн арга хэмжээ авах;
 - 3/ үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор аюулгүй байдлын

-Орчуулга, найруулга зассан

-“зорчигч тээврийн тогтмол нислэг” гэсэн шаардлагыг тодруулсан
-“shall”, “must”-ийн ялгааг гаргасан
-“firearm”-ыг “зэвсэг” гэснийг “галт зэвсэг” болгож залруулсан
-“Зохицуулалттай агаарын ачааны байгууллага, Аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл” гэсэн ойлголтууд шинээр тусгагдсан

агаарын хөлөгт нэвтрэх үйл ажиллагаанд байнгын хяналт тавих;

- (4) Монгол Улсын доторх аюулгүйн хамгаалалттай аэродромын хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүс болон бусад аэродромын үйл ажиллагааны бүсэд агаарын тээвэрлэгчийн байгууламжаар дамжин нэвтрэх, эсхүл агаарын тээвэрлэгчийн зорчигч, ажилтан, тээш, ачаа, багц ачаа, эсхүл агаарын хөлгийн хангалтад ашигладаг бусад хаалгаар дамжин нэвтрэх үйл ажиллагаанд хяналт тавих;
- (5) хэрэв Дарга, агаарын хөлөгт байгаа этгээд, эсхүл агаарын хөлөг, эсхүл аэродромд учрах аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн түвшин нэмэгдсэнийг илрүүлсэн, эсхүл сэжиглэж байгаа бөгөөд энэ нь аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ авахыг шаардаж байгаа бол, Монгол Улсад, эсхүл Монгол Улсаас нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгчийн үйлчилгээний аюулгүйн хамгаалалтыг сайжруулах түр арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- (6) энэ зүйлийн (с)-г харгалзан, агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгаа тээш, ачаа, илгээмж болон шууданд зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;
- (7) хэрэв тухайн агаарын хөлгийн бүхээгт хуулийн дагуу саатуулагдсан, эсхүл хууль хяналтын байгууллагын хяналтын дор аялах шаардлагатай 1, эсхүл хэд хэдэн этгээдийг тээвэрлэх бол тэднийг харгалзагчтай байхыг шаардсан эсэхээс үл хамааран, нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангаж, хөлгийн даргад мэдэгдэх;
- (8) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт зорчигч зөвшөөрөлгүй эд зүйл авч орохоос сэргийлж дамжин өнгөрөх, эсхүл шилжин суух зорчигч болон зорчигчийн гар тээшинд хяналт тавих;
- (9) дараахаас бусад тохиолдолд, дамжин өнгөрөх нислэгээс буусан зорчигчийн үлдээсэн эд зүйлийг агаарын хөлгөөс буулгах, эсхүл нислэг эхлэхийн өмнө бусад арга хэмжээг зохих хэлбэрээр авах:
 - (i) тухайн нислэг эхэлсэн Улсын зорчигчийн аюулгүйн үзлэгийн ажиллагаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц бол; эсхүл
 - (ii) тухайн нислэг нь хуваарьт бус буулт хийж байгаа бол.
- (10) агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр

хяналт тавина;

- 4/ нисэх буудлын хамгаалагдсан болон хориотой бүс, тухайн бүсүүд дэх агаарын тээвэрлэгчийн барилга байгууламжид нэвтрэхэд тээш, ачаа, шуудангийн илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан ба эд зүйлст аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;
- 5/ Агаарын хөлөг, зорчигч, нисэх буудлын эсрэг аюулгүй байдлын заналхийлэл үүссэн тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тогтоох түр зуурын нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх талаар;
- 6/ агаарын хөлгөөр тээвэрлэх тээш, ачаа, шуудангийн илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан ба эд зүйлст аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;
- 7/ хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа нэг ба түүнээс дээш этгээдийг тээвэрлэх тохиолдолд агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байх;
- 8/ шилжин суух, дамжин өнгөрөх зорчигч агаарын хөлөгт ямар нэгэн хориглосон зүйл авч орохоос сэргийлж дээрх зорчигч, тэдгээрийн тээшинд аюулгүй байдлын үзлэг хийх;
- 9/ хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртөж болзошгүй өндөр түвшний нислэгийн дараа зорчигчийг агаарын хөлгөөс гаргахдаа ямар нэгэн зүйл үлдээж болохгүйг анхааруулах;
- 10/ агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, шуудангийн илгээмжээс

аэродромын дотор шилжүүлэх тээш, ачаа, шуудан, агаарын хөлгийн хангалт, нөөц болон агаарын тээвэрлэгчийн хангалтад аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;

(11) ачаа, эсхүл шуудангаас бусад, гэхдээ агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөр тээвэрлэхээр төлөвлөж байгаа илгээх барааны баглаа боодол бүрд (дагалдаагүй, эсхүл арилжааны буухиа хүргэлтийн үйлчилгээ ашиглаж байгаагаас үл хамааран) аюулгүйн үзлэг хийх;

(12) хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт авч орохоос сэргийлэх зорилгоор бүх зорчигч, багийн гишүүд болон тэдгээрийн гар тээшинд агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт орохын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;

(13) агаарын хөлөгт суугаагүй зорчигчийн тээшийг энэ зүйлийн (17)-д шаардсаны дагуу тээвэрлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд, тээвэрлэхээс сэргийлэх;

(14) тухайн чиглэлийн агаарын хөлөгт, хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг нүүж болох сэжигтэй эд зүйл, эсхүл хэвийн бус байдлыг илрүүлэх журмыг багтаасан нислэгийн өмнөх үзлэг хийх;

(15) хэрэв нисэх бүүдлын бүртгэлийн цэгээс өөр газраас эхлэлтэй тээшийг зорчигчийн нислэгээр тээвэрлэх бол, бүртгэсэн цэгээс агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн бүхээгт байрлуулах хүртэл тээшинд аюулгүйн хамгаалалтын хяналт тавих;

(16) энэ зүйлийн (h)-д зааснаас бусад тохиолдолд, хууль бус үйлдэл хийхэд ашиглаж болох зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай эд зүйл, эсхүл бодисыг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихаас сэргийлэх зорилгоор, гар тээшнээс бусад, тээшин дэх бүх эд зүйлийг агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгт ачихын өмнө 108.63-ын дагуу аюулгүйн үзлэг хийх;

(17) зөвхөн тухайн агаарын тээвэрлэгчийн зөвшөөрсөн тээшийг тээвэрлэх;

(18) нислэгийн үед агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс

бусад эзэнгүй, эсхүл үйлчилгээний эд зүйлийг аюулгүй байдлын үзлэгт хамруулах;

11/ агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлс нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зорчигч, нисэх баг болон багийн бусад гишүүд, тэдгээрийн авч яваа гар тээшид аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх;

12/ нислэгээс хоцорсон зорчигчийн тээшийг тээвэрлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү зүйлийн 17-д заасны дагуу зөвшөөрөл авсан байх;

13/ агаарын хөлөгт нислэгийн өмнө зэвсэг, аюултай бодис болон эд зүйлсийг илрүүлэх зорилгоор үзлэг, шалгалт хийх;

14/ тээшийг бүртгэсэн үеэс агаарын хөлөгт ачих хүртэл тээшний аюулгүй байдлыг хангах;

15/ нислэгийн үед агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

16/ агаарын хөлөгт сэжигтэй зүйл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлс, нуусан зэвсэг хайх үед ашиглах шалгах хуудсыг агаарын хөлгийн бүхээгт байрлуулна. (Жич: Сэжигтэй зүйл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлс илэрсэн тохиолдолд түүнийг байрлуулах агаарын хөлгийн хамгийн бага эрсдэлтэй байрлалыг шалгах хуудсанд заасан байх шаардлагатай.)

17/ зөвхөн агаарын тээвэрлэгчийн зөвшөөрсөн тээшийг тээвэрлэх.

-Amend.11-ээр нэмэгдсэн

сэргийлэх.

(с) Дараахаас бусад тохиолдолд агаарын тээвэрлэгч нь зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлөгт ачаа, эсхүл шуудан ачихыг зөвшөөрдөггүй байх үүрэгтэй:

(1) ачаа, эсхүл шууданг Зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас хүлээн авсан ба тухайн ачаа, эсхүл шуудангаар илгээх бараанд;

(i) Зохицуулалттай агаарын ачааны байгууллагаас олгосон аюулгүйн хамгаалалтын мэдэгдэл дагалдсан;

(ii) илгээх бараанд гэмтэл учруулаагүй болохыг бататгах шалгалтыг агаарын тээвэрлэгч хийсэн, эсхүл

(2) хэрэв агаарын тээвэрлэгч нь бусад этгээдээс ачаа, эсхүл шуудан хүлээн авахыг зөвшөөрч байгаа бол, тухайн ачаа, эсхүл шууданд энэ зүйлийн (d)-д заасны дагуу зохих аюулгүйн хамгаалалтын хяналт тавьсан, эсхүл

(3) энэ зүйлийн (с)(1) болон (2)-т заасныг үл харгалзан, хэрэв Сайд, эсхүл Даргаас ачаа, эсхүл шууданд аюулгүйн үзлэг хийх чиглэл өгсөн бол, тухайн ачаа, эсхүл шууданд өгөгдсөн чиглэлийн дагуу аюулгүйн үзлэг хийж, аюулгүй хэлбэрээр хадгалсан.

(d) Хэрэв агаарын тээвэрлэгч нь бусад этгээдээс ачаа, эсхүл шуудан хүлээн авахыг зөвшөөрдөг бол тухайн агаарын тээвэрлэгч энэ зүйлийн (с)(2)-т шаардсан аюулгүйн хамгаалалтын хяналт нь ИНД-109-ийн шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор, дараах дүрмээр шаардсантай дүйцэх байгууламж болон журамтай байх үүрэгтэй:

(1) ИНД-109.53 - Байгууламжийн шаардлага;

(2) ИНД-109.55 - Ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалтын хяналтын журам;

(3) ИНД-109.57 - Аюулгүйн үзлэгийн журам;

(4) ИНД-109.59 - Зөвшөөрөл олгох журам;

(5) ИНД-109.61 - Бүртгэлтэй харилцагчийг бүртгэх журам;

(6) ИНД-109.63 - Ажилтнуудын сургалт;

(в) Зорчигч тээврийн хуваарьт нислэгээр энэ зүйлийн (б)-гийн 7/-д заасан этгээдийг тээвэрлэх тохиолдолд дараахь шаардлагыг хангасан байна:

1/ тухайн этгээдийг харгалзагч дагалдсан байх;

2/ тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болохуйц ямар нэг эд зүйл авч яваагүй гэдгийг түүнийг харгалзагч батламжлах;

3/ тухайн этгээдийн харгалзагч нь хамгаалах хэрэгсэлтэй байх;

4/ агаарын хөлгийн дарга болон ахлах үйлчлэгчид тухайн этгээдийн суудлын дугаар болон аюулгүй байдлын арга хэмжээний талаар мэдэгдсэн байх;

5/ тухайн этгээд, түүнийг харгалзагч нарт спиртийн төрлийн ундаа, хоолны төмөр хэрэгслээр үйлчлэхгүй байх;

6/ тухайн этгээдийг агаарын хөлгийн аваарын хаалганы хажууд буюу аваарын хаалганы суудалтай эгнээнд суулгахгүй байх;

7/ тухайн агаарын хөлгийн зорчигчийн суудал 29 хүртэл бол харгалзагчтай тээвэрлэх этгээдийн тоо нэгээс дээшгүй, 29-өөс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлөгт 25 суудал тутамд нэг байна.

(г) Олон улсын нислэг үйлддэг гадаад, дотоодын агаарын тээвэрлэгчийн зорчигч, тээшний бүртгэлийг гүйцэтгэж буй байгууллагын Аюулгүй байдлын хөтөлбөр нь тухайн тээвэрлэгчийн Аюулгүй байдлын хөтөлбөрийн шаардлагад нийцсэн байна.

-Amend.11-ээр
нэмэгдсэн

(7) [ИНД-109.65 - Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил;](#)

(8) [ИНД-109.67 - Бүртгэл хөтлөх.](#)

(e) [Энэ зүйлийн \(d\)-д шаардсан байгууламж болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл нь ИНД-119, эсхүл ИНД-129-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт багтсан байх ёстой.](#)

(f) [Энэ зүйлийн \(b\)\(7\)-д шаардсан журам нь тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний нислэгээр хуулийн дагуу саатуулагдсан этгээдийг тээвэрлэхтэй холбоотой дараах шаардлагыг бататгах журмыг багтаасан байх ёстой:](#)

(1) [тухайн этгээд нь харгалзагчтай байх;](#)

(2) [харгалзагч нь тухайн этгээд зэвсэг болгон ашиглаж болох эд зүйл авч яваагүй болохыг бататгах;](#)

(3) [харгалзагч нь тухайн этгээдийн үйлдлийг хязгаарлахад тохирох хэрэгслээр тоноглогдсон байх;](#)

(4) [тухайн этгээдийн суудлын байрлал болон аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын талаар хөлгийн дарга болон бүхээгийн ахлах ажилтанд мэдэгдэх;](#)

(5) [тухайн этгээд болон түүний харгалзагчид согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх;](#)

(6) [тухайн этгээдийн хэрэглээнд металл хэрэгсэл ашиглахгүй байх;](#)

(7) [тухайн этгээдийг ослын гарцын зэргэлдээх суудалд, эсхүл эгнээнд суулгахгүй байх;](#)

(8) [тухайн этгээдийг нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн суудалд суулгах;](#)

(9) [29, эсхүл түүнээс цөөн гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай агаарын хөлөгт 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг тээвэрлэх ба гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжийн нэмэлт 25 суудал бүрд 1-ээс дээшгүй саатуулагдсан этгээдийг нэмж тээвэрлэх.](#)

(g) [Хэрэв орон нутгийн агаарын тээвэрлэгч олон улсын агаарын тээвэрлэгчийн нэрийн өмнөөс, эсхүл олон улсын тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээний дамжуулан тээвэрлэлтийн зорчигч, эсхүл тээшний бүртгэлийг гүйцэтгэдэг бол олон улсын агаарын тээвэрлэгч нь орон нутгийн агаарын тээвэрлэгч олон улсын агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг мөрддөг болохыг бататгах үүрэгтэй.](#)

(h) [Сайд, эсхүл Дарга тухайн тээшинд аюулгүйн үзлэг хийхийг шаардсанаас бусад тохиолдолд, энэ зүйлийн \(b\)\(16\) нь олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах тээшинд](#)

<p><u>хамаарахгүй.</u></p> <p>(i) <u>Энэ зүйлийн (с)(1) болон (2)-ын шаардлага нь дараах ачаа, эсхүл шүүданд хамаарахгүй:</u></p> <p>(1)<u>илгээж байгаа дипломат байгууллагын албан ёсны гарын үсэгтэй албан тоот дагалдсан, түүний шинж чанарыг таних гадна тэмдэглэгээтэй, дипломат хайрцагт тээвэрлэж байгаа дипломат шуудан; эсхүл</u></p> <p>(2)<u>олон улсын дамжин өнгөрөх болон шилжин ачигдах ачаа, эсхүл шуудан.</u></p>		
<p>108.57. <u>Нислэгт олгох аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл</u></p> <p>Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь, агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөгт Монгол Улсын аэродромоос нисэн гарах зөвшөөрөл өгөхийн өмнө тухайн нислэгт холбогдох <u>аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хангасан болохыг бататгах журамтай</u> байна.</p>	<p>108.11. Аюулгүй <u>байдлын шаардлагыг биелүүлэх</u></p> <p>Монгол Улсын аль ч аэродромоос зорчигч тээврийн нислэг үйлдэх Тээвэрлэгч нь Аюулгүй байдлын хөтөлбөртөө тусгасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>108.58. <u>Шүүхийн, эсхүл захиргааны хяналтад байгаа зорчигчийг тээвэрлэх (шилжилт)</u></p> <p>(a) <u>Монгол Улсын, эсхүл гадаад улсын Засгийн газрын байгууллагаас шүүхийн, эсхүл захиргааны хяналтад байгаа этгээдийг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэхийг шаардсан тохиолдолд, тухайн этгээд харгалзагчтай аялах эсэхээс үл хамааран, санал болгосон аяллын нөхцөл байдлын талаар үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэнэ.</u></p> <p>(b) <u>Хэрэв үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн этгээдийг тээвэрлэхийг зөвшөөрсөн бол:</u></p> <p>(1) <u>үйл ажиллагаа эрхлэгчийн нислэгийн аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзсэн, ИНД-119, эсхүл ИНД-129-ийн дагуу баталсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрөөр зөвшөөрсөн нөхцөлийг тогтооно;</u></p> <p>(2) <u>хөлгийн даргад мэдэгдэнэ.</u></p> <p>(c) <u>Холбогдох байгууллага нь эдгээр бүх нөхцөлийг дагаж мөрдөнө.</u></p>		<p>- Part 19-өөс шилжүүлсэн</p>
<p>108.59. <u>Ажилтны сургалт</u></p> <p>(a) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн <u>хамгаалалтын</u> хөтөлбөр нь дараах шаардлагыг бататгах журамтай байх ёстой:</p> <p>(1) аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт дэлгэрэнгүй заасан аюулгүйн хамгаалалтын журмыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээсэн ажилтнууд нь үүргээ чадварлагаар гүйцэтгэхэд хангалттай сургалтад хамрагдсан байх;</p> <p>(2) тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээ болон бусад</p>	<p>108.13. Аюулгүй байдлын сургалт</p> <p>(a) Тээвэрлэгч нь “Аюулгүй байдлын <u>сургалтын</u> хөтөлбөр” боловсруулах ба хөтөлбөрт дараахь шаардлагуудыг тусгасан байна:</p> <p>1/ аюулгүй байдал хариуцсан албан тушаалтны сургалтын талаар;</p> <p>2/ агаарын хөлгийн нисэх баг болон багийн бусад гишүүдийн</p>	

<p>үйлчилгээнд ажиллаж байгаа бусад бүх ажилтнууд нь агаарын тээвэрлэгч болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын талаар үндсэн мэдлэгтэй байх;</p> <p>(3) сургалтыг агаарын тээвэрлэгчээс зөвшөөрөгдсөн этгээдийн удирдан зохион байгуулсан хэлбэрээр гүйцэтгэсэн байх;</p> <p>(4) сургалтад хамрагдсан байхыг шаардсан этгээд нь сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд 3 жилээс ихгүй давтамжтай хамрагдах.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:</p> <p>(1) <u>анхан шатны сургалт болон давтан сургалтын холбогдох үе шат;</u></p> <p>(2) <u>тухайн зохион байгуулсан сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл үр чадварын үнэлгээ;</u></p> <p>(3) <u>холбогдох аюулгүйн хамгаалалтын хяналтын үүрэг тус бүрээр сургалтын хөтөлбөрийн задаргаа.</u></p> <p>(c) [Хүчингүй]</p>	<p>сургалтын талаар:</p> <p>(i) нислэгийн үед гарах хэрэг зөрчлийг ноцтой болохыг тодорхойлох чадвар;</p> <p>(ii) нисэх багийн холбоо, харилцаа;</p> <p>(iii) бие хамгаалах хэрэгслийг ашиглах чадвар;</p> <p>(iv) заналхийллийн янз бүрийн нөхцлийн талаар зохион байгуулах бодит дасгал сургуулилт;</p> <p>(v) агаарын хөлгийг хамгаалах нисэх багийн журам;</p> <p>(vi) агаарын хөлгийг шалгах журам болон тэсрэх бөмбөг байршуулах хамгийн бага эсрдэлтэй байрлалын заавар;</p> <p>3/ агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан болон үйлчилгээтэй холбоотой бусад ажилтан нь нисэхийн аюулгүй байдлын талаар үндсэн мэдлэгтэй байх тухай.</p>	<p>-Amend.11-ээр нэмэгдсэн</p>
<p>108.60. Бүртгэл хөтлөх</p> <p>(a) Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь, 108.59-ийн дагуу сургалтад хамрагдсан байхыг шаардсан этгээдийн нягт нямбай бүртгэлийг хөтлөхөд шаардлагатай тухайн бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан журамтай байх ёстой:</p> <p>(1) гүйцэтгэж байгаа сургалтын үе шат бүрийн;</p> <p>(2) тухайн зохион байгуулсан сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл үр чадварын үнэлгээний.</p>		<p>-Amend.11-ээр нэмэгдсэн</p>
<p>108.61. Зөрчлийг мэдээлэх</p> <p>Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь тухайн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөгтэй холбоотой аюулгүйн хамгаалалтын зөрчлийн талаар ИНД-12-ын дагуу <u>Даргад</u> мэдээлэх хэрэв хамааралтай бол тайлан гаргах журамтай байна.</p>	<p>108.15. Зөрчлийн тайлан, мэдээ</p> <p>(a) Тээвэрлэгч нь агаарын хөлгийн аюулгүй байдлын зөрчлийн тухай тайланг ИНД-12-т заасны дагуу гаргах журмыг Аюулгүй байдлын хөтөлбөртөө тусгана.</p> <p>(б) Агаарын хөлгийн дарга нь хөндлөнгийн хууль бус үйлдлийн дараа тайланг даруй гаргаж <u>Иргэнийн нисэхийн ерөнхий газарт</u> хүргүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

108.63. Аюулгүйн үзлэг

Энэ дүрмийн 108.53 болон 108.55-д [шаардсан](#) зорчигч, багийн гишүүд болон тээшний аюулгүйн үзлэгийг дараах байгууллага гүйцэтгэх ёстой:

- (1) Монгол Улсаас, эсхүл Монгол Улс дотор агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохиолдолд, ИНД-140-ийн дагуу олгосон [нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч](#);
- (2) Монгол Улсын [гаднах аэродромоос](#) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохиолдолд нисэн гарах улсын зохих эрх бүхий байгууллагаас [аюулгүйн үзлэг хийхээр зөвшөөрөгдсөн байгууллага](#).

108.17. Аюулгүй байдлын үзлэг

(а) Энэхүү дүрмийн 108.7 болон 108.9-д **заасан** зорчигч, нисэх баг болон багийн бусад гишүүд, тэдгээрийн тээшний аюулгүй байдлын үзлэгийг дараах байгууллага хийнэ:

- 1/ Монгол улсад, эсхүл тухайн улсаас нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн хувьд ИНД-140-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллага;
- 2/ Монгол улсад бүргэлтэй агаарын тээвэрлэгч тухайн улсаас гадна нислэг үйлдэхэд тухайн улсын холбогдох эрх бүхий байгууллага.

-Орчуулга, найруулга зассан

Дүрмийн боловсруулалтын хэлтэс